



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 4/05

Чингис хот

2021 оны цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Ж.Ганбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч дарга	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга, Хурандаа
Гишүүд:	Г.Сэдэдмаа	Статистикийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Б.Төрхүү	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
	С.Галбадрах	Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, хошууч
		Сумдын Засаг дарга, Тосгоны Захирагч нар
Нарийн бичгийн дарга:	Л.Цэнддорж	Цэргийн штабын Тоо бүртгэлийн офицер, хошууч

2. 2021 оны цэргийн бүртгэлийг 2021 оны 1 дүгээр сарын 20-оос 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

3. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Цэргийн бүртгэлийг зохион байгуулахдаа Улсын болон аймгийн онцгой комиссоос тогтоосон халдвар, хамгааллын дэглэмийг чанд сахих, энэ жил шинээр 18 нас хүрсэн Цэргийн үүрэгтний үнэмлэх авах иргэнээс бусад цэргийн үүрэгтнийг зайнаас буюу үүрэн телефон, цахим шуудан ашиглан бүртгэх, сумын комиссыг холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, 2020 оны жилийн эцсийн хүн амын тоотой тулган; тоо бүртгэлийн материал, мэдээ судалгааг маягтын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд сумын Засаг даргын Тамгын газрын дарга /тосгоны Захирагчийн ажлын албаны дарга/-аар хуваарийн дагуу хүргүүлэхийг сумын Засаг дарга, Тосгоны Захирагч нарт үүрэг болгосугай.

231010023

2.

4. Цэргийн бүртгэлийн явцтай танилцах, шалган зааварлах хуваарийг 1 дүгээр, сумдын цэргийн бүртгэлийн материал тушаах хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

5. Цэргийн бүртгэлийн явцын байдалд хяналт шалгалт хийж, заавар зөвлөмж өгөх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, цэргийн бүртгэлийн материалыг тогтоосон хугацаанд сумдаас хүлээн авч зааврын дагуу нэгтгэх, нэгдсэн дүн мэдээг 2020 оны 03 дугаар сарын 10-ны дотор Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэхийг комиссын дарга /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын 2020 оны  
...01... дугаар сарын...06... өдрийн ...7/05...  
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

2021 ОНЫ ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙН ЯВЦТАЙ ТАНИЛЦАЖ,  
ШАЛГАН ЗААВАРЛАХ ХУВААРЬ

д/д	Сумдын нэр	Шалган зааварлах хуваарь	Он, сар, өдөр
1	Биндэр	Хурандаа Н.Хурэлээ	2021.01.20
2	Баян-Адарга		2021.01.20
3	Дадал		2021.01.21
4	Норовлин		2021.01.22
5	Мөрөн	Хошууч Л.Цэнддсрж	2021.01.25
6	Жаргалтхаан		2021.01.25
7	Цэнхэрмандал		2021.01.26
8	Баянхутаг		2021.01.27
9	Хэрлэн 1 дүгээр баг	Хошууч Л.Цэнддорж	2021.01.20-
10	Хэрлэн 2 дугаар баг		2021.02.10
11	Хэрлэн 3 дугаар баг		
12	Хэрлэн 4 дүгээр баг	Хошууч С.Галбадрах	2021.01.20- 2021.02.10

Аймгийн Засаг даргын 2020 оны  
 ...01... дугаар сарын ...01... өдрийн ...11/05...  
 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

2021 ОНЫ ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙН МАТЕРИАЛ ТУШААХ ХУВААРЬ

д/д	Сумдын нэр	Он, сар, өдөр	Цаг	Хариуцах эзэн
1	Баянхутаг	2021.02.17	09.00	О.Цэрэннадмид
2	Галшар		12.00	Ш.Цэвэлсүрэн
3	Бор-Өндөр		15.00	З.Ууганжаргал
4	Дархан	2021.02.18	09.00	Ш.Отгонжаргал
5	Баянмөнх		12.00	А.Болормаа
6	Дэлгэрхаан		15.00	З.Ганбаатар
7	ХБУлаан		16.00	Ж.Март
8	Цэнхэрмандал	2021.02.19	09.00	Ү.Ичинхорлоо
9	Жаргалтхаан		12.00	Г.Мөнхсайхан
10	Мөрөн		15.00	Н.Намжилноров
11	Өлзийт	2021.02.22	09.00	Д.Ганцэцэг
12	Өмнөдэлгэр		12.00	Л.Баярмаа
13	Гурванбаян		15.00	М.Мөнхжаргал
14	Батширээт	2021.02.23	09.00	Б.Эрдэнэчимэг
15	Биндэр		12.00	Р.Бадрах
16	Баян-Адрага		15.00	О.Баттогтох
17	Дадал	2021.02.24	09.00	Д.Гэрэлмаа
18	Норовлин		12.00	Н.Лхагва
19	Баян-Овоо		15.00	Б.Сарантуяа
20	Батноров	2021.02.25	09.00	М.Ган-Эрдэнэ
21	Бэрх		12.00	О.Батмандах
22	Хэрлэн 1 дүгээр баг	2021.02.26	09.00	Б.Эрдэнэбилэг
23	Хэрлэн 2 дугаар баг		12.00	Г.Мягмарсайхан
24	Хэрлэн 3 дугаар баг		15.00	Ө.Өлзийцэцэг
25	Хэрлэн 4 дүгээр баг	2021.02.27	09.00	П.Эрдэнэчимэг
26	Хэрлэн 5 дугаар баг		11.00	Х.Өлзийбат
27	Хэрлэн 6 дугаар баг		13.00	Е.Наранцэцэг
28	Хэрлэн 8 дугаар баг		15.00	Ж.Шинэбаяр